ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 11 сарын 07 өдөр Дугаар 03/51 Баян-Өндөр сум

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.19, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2026 онд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх чиглэлээр бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХБАТ

6125010138

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн
03/51 дугаар тогтоолын хавсралт

АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ, ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР 2026 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах болон хамтран ажиллах байгууллага	Суурь түвшин	Хүрэх түвшин	Шаардагдах зардал (төгрөг)	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1. Орон нутагт хэрэгжүүлэх бодлого хөтөлбөрийн хүрээнд:							
1.1	Төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж гаргуулан мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах	2026 оны I сард	Онцгой байдлын газар	Захирамжийн хүрээнд биелэлтийн хэрэгжилт 95% -тай ажилласан.	Захирамжийн биелэлтийг 100% хангаж ажиллах	-	-
1.2	Баян-Өндөр, Жаргалант сумдын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гаргасан төлөвлөгөөнд тодотгол хийх	2026 оны II сард	Онцгой байдлын газар, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	Төлөвлөгөөнд тодотгол хийгдэж үр дүн 95% -тай ажилласан	Төлөвлөгөөнд тодотгол хийж, үр дүнг 98% хангуулах	-	-
1.3	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх. /Шатахуун, дулаан мэдрэгчтэй нисэх төхөөрөмж /дрон/	2026 оны I сард	Онцгой байдлын газар	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хөрөнгийн эх үүсвэрийг шийдүүлэн ажилласан.	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хөрөнгийн эх үүсвэрийг 100% шийдүүлж ажиллах	Шатахуун нөөц 5тн-АИ-92 2тн- Дизель 13,7 сая /удирдамжит ажил/,	-

1	2	3	4	5	6	7	8
						тараах материал-2,5 сая	
2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны чиглэлээр:							
2.1	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран радио, телевизийн нэвтрүүлэг шторк бэлтгэж иргэд олон нийтэд мэдээлэл өгөх	II, III, IV улиралд	Онцгой байдлын газар, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	640 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг хүргэсэн.	640 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг хүргэх	10 сая	-
2.2	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гарын авлага, тараах материал шинэчлэн боловсруулж иргэд, олон нийтэд танилцуулах, тараах	II, IV улиралд	Онцгой байдлын газар, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	6396 иргэнд 6396 ширхэг сэрэмжлүүлэх тараах материал /боршур/ тараасан.	6500 иргэнд 6500 ширхэг сэрэмжлүүлэх тараах материал /боршур/ тараах	-	-
2.3	Ой мод руу орох гол зам, зорчих газар харагдахуйц өндөрлөг газарт гал түймрээс урьдчилан сэргийлэх самбар байрлуулах, одоо байгаа самбар зураг тэмдэглэгээг сэргээх.	II улиралд	Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	Аймгийн ойн сан бүхий 14 хэсэгт ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх самбар байршуулсан.	Аймгийн ойн сан бүхий 14 хэсэгт ой хээрийн түймрээс урьдчилан одоо байгаа самбарын тэмдэглэгээг сэргээх	1 сая	-
2.4	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түймэртэй тэмцэх анхан шатны мэдээлэл олгох сургалтыг ойн нөхөрлөлүүдэд зохион байгуулах.	II, IV улиралд	Онцгой байдлын газар, Байгаль орчны газар, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	Жаргалант сумын 5 нөхөрлөлийн 57 иргэнд анхан шатны мэдлэг олгох сургалтад хамруулсан.	Баян-Өндөр сумын-1, Жаргалант сумын 4 нөхөрлөлийн 57 иргэнд анхан шатны мэдлэг олгох хамруулах	-	-

1	2	3	4	5	6	7	8
2.5	Зуны хэт халалтын улмаас ой, хээрийн түймрийн аюулын зэрэглэл нэн аюултай, аюултай түвшинд хүрсэн үед хөдөлгөөнт анхааруулга сурталчилгааны ажил зохион байгуулах	Тухайн үед	Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ, Байгаль орчны газар, УЦУОШГ	12 удаагийн хөдөлгөөнт анхааруулга сурталчилгааны ажил зохион байгуулсан	12 удаагийн хөдөлгөөнт анхааруулга сурталчилгааны ажил зохион байгуулах	-	-
2.6	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр сайн дурын идэвхтэн, бүлгийн судалгаа гаргах, тодотгох	II улиралд	Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	30 сайн дурын иргэдийг томилгоожуулсан.	30 сайн дурын иргэдийг тодотгох, шаардлагатай тохиолдолд шинээр томилгоожуулах	-	-
2.7	Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, унтраах арга ажиллагааны талаар сургалтыг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран зохион байгуулах	II, IV улиралд	Онцгой байдлын газар, Байгаль орчны газар	Төрийн цэргийн болон хууль сахиулах 3 байгууллагуудтай дадлага сургуулийг зохион байгуулсан	Төрийн цэргийн болон хууль сахиулах 3 байгууллагуудтай дадлага сургуулийг зохион байгуулах	-	-
2.8	Бүс нутгийн хөрш зэргэлдээ орших аймаг, сумдын мэргэжлийн ангитай хамтарсан сургалт, тандалтын ажлыг зохион байгуулах, ой, хээрийн түймэр гарсан үед нэмэлт хүн, хүч татан оролцуулах	Жилдээ	Онцгой байдлын газар, Байгаль орчны газар	2 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 87 ойн нөхөрлөл болон мэргэжлийн анги хамрагдсан.	2 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 87 ойн нөхөрлөл болон мэргэжлийн анги, сайн дурын иргэдийг хамруулах	-	-
3. Ойн аж ахуйн нэгж байгууллага, нөхөрлөлүүдийн талаар:							
3.1	Хуурайшилтын улиралд цаг уурын мэдээлэл нэгтгэж, түймрийн аюулын	Гал түймрийн	Байгаль орчны газар, УЦУОШГ Баян-Өндөр,	Хуурайшилтын улиралд нийт 6 удаагийн давтамжтай түймрийн	Түймрийн аюулын зэрэглэлийг холбогдох байгууллагад	-	-

1	2	3	4	5	6	7	8
	зэрэглэл тогтоох, холбогдох байгууллагыг шуурхай мэдээллээр хангах	аюултай үед	Жаргалант сумын ЗДТГ	аюулын зэрэглэлийг холбогдох байгууллагад шуурхай мэдээллээр хангаж ажилласан.	шуурхай мэдээллээр хангаж ажиллах		
3.2	Сумдын ЗДТГ болон нөхөрлөл аж ахуй нэгж, байгууллагуудын түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг шалгах, түймэртэй тэмцэх багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх.	II, III улиралд	Онцгой байдлын газар, Байгаль орчны газар, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	10 ойн нөхөрлөлийн багаж хэрэгсэл, техникийн бэлэн байдлыг шалгаж ажилласан.	10 ойн нөхөрлөлийн багаж хэрэгсэл, техникийн бэлэн байдлыг шалгаж ажиллах	3 сая	-
3.3	Ой, хээрийн түймрийн аюултай болон нэн аюултай үед ойгоос мод бэлтгэх үйл ажиллагааг хязгаарлах	Түймрийн аюултай үед	Байгаль орчны газар, УЦУОШГ	-	2 удаагийн хяналт шалгалтыг 97%-тай хангаж ажиллах	-	-
4. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл, шалгалтын чиглэлээр:							
4.1	Түймрийн аюултай үед сургууль төгсөгчдийн баяр, хавар, намрын аялал зугаалгын үеэр ойн бүсэд зорчихыг хязгаарлах аймгийн Засаг даргын Захирамж гаргуулах, эргүүл шалгалт хийх, иргэдэд анхааруулга санамж өгөх	V, VI сард	Онцгой байдлын газар, Байгаль орчны газар, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	6396 иргэнд 6396 ширхэг сэрэмжлүүлэх тараах материал (боршур) тараасан.	6500 иргэнд 6500 ширхэг сэрэмжлүүлэх тараах материал (боршур) тараах	2,5 сая	-
4.2	Орхон аймгийн нутаг дэвсгэрийн ойролцоох амралт, сувиллын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжүүдийн ой, хээрийн түймрээс	II, III улиралд	Онцгой байдлын газар, Байгаль орчны газар	4 амралтын газарт хяналт шалгалтыг зохион байгуулсан	2 амралтын газарт хяналт шалгалтыг зохион байгуулах	-	-

1	2	3	4	5	6	7	8
	урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангасан байдалд тогтмол хяналт шалгалт зохион байгуулах						
4.3	Ой, хээрийн түймрийн аюултай үед хөрш зэргэлдээ аймгуудын сумдтай хамтран эргүүл шалгалтыг зохион байгуулах	Тухайн үед	Онцгой байдлын газар	220 алба хаагч ногоон бүсийн эргүүлээр ажиллаж, Баян-Өндөр, Жаргалант сумдын 1750 айл өрхийн 3852 иргэнд зөвлөмж хүргэж ажилласан.	220 алба хаагч ногоон бүсийн эргүүлээр ажиллах, Баян-Өндөр, Жаргалант сумдын 1765 айл өрхийн 3932 иргэнд зөвлөмж хүргэж ажиллах	-	-
4.4	Хуурайшилтын улиралд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах.	II, III улиралд	Онцгой байдлын газар, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ	1 нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 592 иргэн хамрагдсан.	1-2 нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж 500 иргэн хамруулах	-	-
4.5	Цаг үеийн нөхцөл байдлаас хамааруулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эргүүл шалгалтын ажлын тоог нэмэгдүүлж, эрчимжүүлэх	II, III улиралд	Онцгой байдлын газар, Баян-Өндөр, Жаргалант сумын ЗДТГ, Байгаль орчны газар, Цагдаагийн газар, Сум дундын ойн анги	2610 тээврийн хэрэгсэл, 6396 иргэнд, тараах материалыг хүргэн ажилласан.	2700 тээврийн хэрэгсэл, 6459 иргэнд, тараах материалыг хүргэн ажиллах	-	-
Нийт 4 хэсэг, 21 заалттай. Шаардагдах зардал-30,2 сая төгрөг.							

-- 000 --